

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх эрхэм зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ”, “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийг хийх”-ээр тусгасан бөгөөд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой, хүртээмжтэй болгож, татварын орчныг сайжруулах, бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлэх, татварын өр хураах ажиллагааг уян хатан зохицуулдаг болох, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтууд туссан.

Монгол Улс 1998 онд нэмэгдсэн өртгийн албан татварын тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд 2007 он болон 2015 онд уг хуулийг шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас үүдэн инфляц, төгрөгийн ханш, хүүгийн түвшин нэмэгдэж, голчлон бага, дунд орлоготой иргэн, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих тухай асуудал чухал ач холбогдолтой болсон. Иймд иргэдийн эцсийн хэрэглээндээ төлдөг нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулж, аж ахуйн нэгжүүдэд үүсгэж буй хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх шаардлага үүссэнтэй холбоотойгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай улс орон даяар давхардсан тоогоор 13,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим санал хүлээн авсан. Хэлэлцүүлгийн үер НӨАТ суутган төлөгчийн босгыг нэмэгдүүлэх, үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг шууд хасах, ажил эрхлэлтийг дэмжсэн хөшүүргийг бий болгох, орлого хүлээн зөвшөөрөх суурь зарчмыг өөрчлөх, бүх нийтээрээ жигд төлдөг байх зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан татварын бодлогыг илүү уян хатан, ойлгомжтой болгож, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өрхийн татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт чөлөөлөлтийг илүү оновчтой, хүртээмжтэй болгох чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн байна.

Дээрх үндэслэл, шаардлагын дагуу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах үндсэн зорилгод нийцүүлж боловсрууллаа. Үүнд:

1.Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах: Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олон улсын чиг хандлага, зарчимд нийцүүлэн оновчтой, хүртээмжтэй болгох замаар иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг шаталсан хэлбэрээр 100 хүртэлх хувиар буцаан олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

2.Бизнесийн идэвхжилийг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг олгох: Аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн хомсдол, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бүх нийтээрээ тэгш шударга төлж, бизнес эрхлэхэд нэмэлт дарамт болдоггүй байх нөхцөлийг бүрдүүлсэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, өрхийн хэрэглээндээ төлдөг татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалж, бизнес, ажил эрхлэлтийг дэмжих ба нэмэгдсэн өртгийн албан татварыг олон улсын жишгийн дагуу хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь бизнес эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэж, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бизнесийн идэвхжих, тэлэх бололцоог ханган, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Цаашид хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан системийг нэвтрүүлснээр татвар төлөгчид шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй авч, татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой асуудлуудыг урьдчилан шийдвэрлэж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаа, нийгэм, эдийн засагт эергээр нөлөө үзүүлнэ.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх эрхэм зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ”, “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийг хийх”-ээр тусгасан. Үүнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой, хүртээмжтэй болгож, татварын орчныг сайжруулах, бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлэх, татварын өр хураах ажиллагааг уян хатан зохицуулдаг болох, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг олон зорилтууд туссан.

Монгол Улс 1998 онд нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлсэн. Улмаар 2007 он болон 2015 онд уг хуулийг шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас үүдэн инфляц, төгрөгийн ханш, хүүгийн түвшин нэмэгдэж, голчлон бага, дунд орлоготой иргэн, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих тухай асуудал чухал ач холбогдолтой болсон. Иймд иргэдийн эцсийн хэрэглээндээ төлдөг нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулж, аж ахуйн нэгжүүдэд үүсгэж буй хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх шаардлагын үүссэнтэй холбоотойгоор тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 38 дугаар зүйлд заасны дагуу татварын шинэчлэлийг улс орон даяар бүх нийтийг хамарсан өргөн хүрээний хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлүүлж, татвар төлөгч, эрдэмтэн судлаач, худалдааны танхим зэрэг бүх талын оролцоог хангуулан нээлттэй санал авах ажлаар эхлүүлж, фокус группийн судалгааг хийсэн. Өнгөрсөн хугацаанд Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар, Эдийн засгийн хөгжлийн зөвлөлтэй хамтран улс орон даяар,

давхардсан тоогоор 13,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээн авсан.

Хэлэлцүүлгийн үр дүнд нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулах, үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн татварыг шууд хасах, ажил эрхлэлтийг дэмжсэн хөшүүргийг бий болгох, орлого хүлээн зөвшөөрөх суурь зарчмыг өөрчлөх, бүх нийтээрээ жигд төлдөг байх зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан татварын бодлогыг илүү уян хатан, ойлгомжтой болгох, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өрхийн татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт чөлөөлөлтийг илүү оновчтой, хүртээмжтэй болгох чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлага үүссэн байна.

Дээрх үндэслэл, шаардлагын дагуу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дараах үндсэн зорилгод нийцүүлж боловсруулсан. Үүнд:

1.Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах: Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олон улсын чиг хандлага, зарчимд нийцүүлэн оновчтой, хүртээмжтэй болгох замаар иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг шаталсан хэлбэрээр 100 хүртэл хувиар буцаан олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

2.Бизнесийн идэвхжилийг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг олгох: Аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн хомсдол, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бүх нийтээрээ тэгш шударга төлж, бизнес эрхлэхэд нэмэлт дарамт болдоггүй байх нөхцөлийг бүрдүүлсэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд ажилтны хөгжил, хүний нөөцийн бодлогыг дэмжих, ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад татварын тодорхой дэмжлэгийн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Улмаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу татварын хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлал, дагалдах тооцоо, судалгааны хамт 60 хоногийн хугацаанд Сангийн яамны цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулан санал аваад байна. Энэ хүрээнд олон нийтээс Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор 342 санал ирүүлсэн байна.

Хуулийн төсөлд олон нийтээс ирүүлсэн болон хэлэлцүүлгийн үеэр гаргасан саналтай холбоотой хуулийн төсөлд дараах зүйлсийг нэмж тусгалаа. Үүнд:

1.“Бүх нийтээрээ жигд, тэгш шударга төлдөг байх, НӨАТ нь аж ахуйн нэгжүүдэд нэмэлт дарамт үүсгэдэггүй байх” зорилгын хүрээнд бүх нийтээрээ нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгч болж, жилийн 400 сая хүртэлх төгрөгийн борлуулалтын орлоготой татвар төлөгч нь хялбаршуулсан горимд хамрагдаж, улирал бүр тайлагнаж, борлуулалтын орлогоос 1 хувиар төлөх зохицуулалтыг тусгалаа.

2. “Татварын бааз суурийг хамгаалах” зорилгын хүрээнд гадаад улсаас Монгол Улсад оршин суугч этгээдэд цахимаар үзүүлж буй үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулж, тэдгээрийг суутган төлөгчөөр бүртгүүлэх харилцааг тусгалаа.

Бараа, үйлчилгээний нэр томъёоны тодорхойлолтод “мөнгөн хөрөнгө, цахим мөнгө, виртуал хөрөнгө”-ийг нэмж тусган өргөжүүлж, албан татвар суутган төлөгчид тавигдаж байсан үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий этгээд байсныг хасаж, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг хөнгөрүүлэв. Мөн албан татвар суутган төлөгчийг хялбаршуулсан журмаар бүртгэх нөхцөлийг бүрдүүлээ.

Албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээнээс өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ хассан бөгөөд түүнчлэн албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээнд тавигдах нөхцөл, шаардлагаа борлуулалтыг аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хийсэн байх хасаж тооцохоор болгов.

Бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу хүлээн зөвшөөрч, борлуулалтын нэхэмжлэл, эсхүл төлбөрийн баримт үйлдсэнээр татвар ногдуулахаар, мөн бараа импортоор оруулсан бол уг барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдрөөр албан татвар ногдуулах хугацааг тогтоож байсан зохицуулалтыг хассан.

Импортоор оруулсан, эсхүл үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн түлшний албан татвар тооцох үнэлгээнд 0-10 хувиар ногдуулах, уг ногдуулах албан татварын хувийг салбарын онцлогийг харгалзан Засгийн газар тогтоож байсныг болилуулж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг тусгалаа.

Иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээр дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгсэл, жилийн 50 саяас доош төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ борлуулсан этгээд болон бусад албан татвараас чөлөөлдөг байсан зарим бараа, үйлчилгээг хасах зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгасан.

Албан татвар төлөгч хуульд заасан буцаан олголтын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд тухайн сарын 500,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн татварыг 100 хувь, 500,001-800,000 төгрөг хүртэлх худалдан авалтад төлсөн татварыг 50 хувь, 800,001 төгрөгөөс дээш худалдан авалтад төлсөн татварыг 20 хувиар хөнгөлөлт үзүүлэх зохицуулалтыг төсөлд тусгалаа.

Татвар суутган төлөгч этгээд нь татварын хялбаршуулсан горимд бүртгүүлэх хүсэлтийг татвар төлөгчийн гэрчилгээ олгосноос хойш нэг сарын дотор гаргаагүй, 2025 онд татвар ногдох орлогогүй, 400 сая төгрөгт хүрээгүй этгээдийг татварын алба хялбаршуулсан горимд бүртгэж татвар төлөгчид мэдэгдэх зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төсөлд уг хялбаршуулсан горимд ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах, согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох, газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос

хайх, олборлох, борлуулах зэрэг ажил, үйлчилгээ хамрагдахгүй байх зохицуулалтыг тусгасан болно.

Хуулийн төсөлд 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд худалдан авсан үндсэн хөрөнгөд төлсөн татварыг 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу хувь тэнцүүлэн хасагдуулж тооцохоор, мөн хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд хамаарах ногдуулалт болон төлөлт, буцаан олголт, урамшуулал, хойшлуулан бүртгэсэн татвартай холбоотой харилцааг уг хуулийг баримтлан тодорхойлох шилжилтийн үеийн зохицуулалтыг нэмж тусгасан.

Гадаад улсаас цахимаар үзүүлэх үйлчилгээг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр зохицуулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, өрхийн хэрэглээндээ төлдөг татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалж, бизнес, ажил эрхлэлтийг дэмжих ба нэмэгдсэн өртгийн албан татварыг олон улсын жишгийн дагуу хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь бизнес эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэж, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бизнесийн идэвхжих, тэлэх бололцоог ханган, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Цаашид хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан системийг нэвтрүүлснээр татвар төлөгчид шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй авч, татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой асуудлуудыг урьдчилан шийдвэрлэж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаа, нийгэм, эдийн засагт эергээр нөлөө үзүүлнэ.

---oOo---